

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРААС
2019 ОНЫ 06 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 21


Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 06 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 2358 ширхгийг шинээр хэвлэн, 1066 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 32 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын 57 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн мэдээллийг цахим архивт оруулсан байна. Мөн гадаадын дөрвөн иргэнд регистрийн дугаар олгосон. Үйлчилгээний танхимд 2188 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авчээ. Нийт 2718 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1141, 7585-1882 дугаарын утсаар 102, биечлэн 513, автомат хариулагчаар 962 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Австрали Улсын Канберра хот дахь Элчин сайдын яам болон Шинэ Зеланд дахь өргөмжит консулын ажилтан нарт утсаар болон гурван удаагийн цахим шуудангаар виз, бүртгэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, 20 улсын 37 гадаадын иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



Цахим визийн зөвшөөрлийн хүрээнд олон улсын хилийн боомт дээрээс “J” ангиллын 174, “B” ангиллын 45 визийн зөвшөөрөл, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 181 визийн зөвшөөрөл, нийт давхардсан тоогоор 240 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 173 аж ахуйн нэгж, байгууллагын 400 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэсэн байна.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын хоёр мэргэжилтэн ажиллаж 214 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 61 иргэнд визийн зөвшөөрөл, 51 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 146 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 16 иргэний ангиллыг сольж, 44 иргэнд бүртгэл, нэг иргэнд хаягийн өөрчлөлт, 16 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 96 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 06 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 13.0 хувиар, виз олголт 17.9 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 7.6 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 23.2 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 25.5 хувиар өссөн, харин хувийн урилга олголт 19.6 хувиар, түр ирэгчийн бүртгэл 19.0 хувиар, түр ирэгчийн хасалт 15.7 хувиар, визийн сунгалт 29.0 хувиар тус тус буурсан байна.


Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, мөн нэг хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулсны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан байна.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын гурван улсын харьяат болох хүсэлт гаргасан дөрвөн иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэг удаагийн зарлигаар 15 иргэн Монгол Улсын харьяатаас гарсан байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 40 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3195 иргэн бүртгэлтэй байна.



Тайлангийн хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан гурван олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 06 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 95 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.

Гадаадын улсын гэр бүлд үрчлүүлсэн дөрвөн хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээ.

1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн зургаан улсын 15 иргэнийг байгууллагын даргын дөрвөн удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын хоёр удаагийн тушаалаар гадаадын хоёр улсын хоёр иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, гурван удаагийн тушаалаар гурван улсын гурван иргэн, харьяалалгүй нэг хүний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу гадаадын 188 иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг 42 гадаадын иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн нэг захирамжаар гадаадын нэг иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 97 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн байна.

Тайлангийн хугацаанд зургаан удаагийн төлөвлөгөөт, 10 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 57 аж ахуйн нэгж, байгууллага, 749 гадаадын иргэнийг хамруулсан ба 90 гадаадын иргэн, 67 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 141 иргэн/, нэг уригч иргэн /гадаадын нэг иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 91,930,000 /ерэн нэгэн сая есөн зуун гучин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2019 оны 06 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 4.7 хувиар өссөн, харин зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 10.7 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 21.1 хувиар тус тус буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажлын чиглэлээр:

Монгол Улсад хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын мэдээ, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолын тус байгууллагад холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр хэрэгжилтийг хурлын тэмдэглэлийн хамт, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” албан даалгаврыг 2018-2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилт, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилт, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн тус байгууллагад холбогдох арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 05 дугаар сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, байгууллагын 2019 оны 05 дугаар сарын үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад тус тус албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулах салбарын яамны ажлын хэсэгт холбогдох албан хаагч нар оролцож, шаардлагатай мэдээ, мэдээллийн ажлын хэсэгт хүргүүлсэн.

Мэдээллийн төвийн мэргэжилтний ажлын байранд зураг авалт хийж дүнг удирдлагад илтгэх хуудсаар танилцуулав. Мөн албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийн хүргүүллээ.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Бээжин хотод суух Элчин сайдын яамны төлөөлөгч цагдаагийн хурандаа, сургагч багш Дирк Мальцаны “Баримт бичгийн нууцлалын үзүүлэлт” сэдэвт дөрвөн өдрийн сертификаттай сургалтад 19 албан хаагчийг хамрууллаа. Мөн албан хаагчдын мэдээллийн цагаар Гандан тэгчлэн хийдийн тэргүүн хамба Д.Чойжамц “Хувь хүний хүмүүжил”, Дотоод Хэргийн Их Сургуулийн багш, дэд профессор Ж.Нямдулам “Жендерт суурилсан хүчирхийлэл ба ажлын байрны бэлгийн дарамт”, “NMLL буюу Норвегийн тусламжийн байгууллага”-ийн Улаанбаатар дахь салбарын захирал

М.Чанцалсүрэн, төслийн зохицуулагч Б.Цогбаяр нар “Хөгжлийн бэрхшээлийн талаар баримтлах бодлого”, “Корпорэйт трэйнинг” сургалтын байгууллагын багш С.Баатарсүрэн “Үйлчилгээний албан хаагчийн зан харилцаа, ажил үйлчилгээний стандарт”, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтэн “Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга” /гадаадын иргэнтэй холбогдолтой зүйл, заалт/ зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор байгууллагын төвийн 150 албан хаагч хамрагдаж, орон нутаг дахь газрын 51 албан хаагчдад онлайн хэлбэрээр тус тус хүргэсэн.

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт “Жуулчин ангиллын виз, жуулчдын анхаарах зүйл” сэдвийн хүрээнд холбогдох албан хаагчид оролцож мэдээлэл өглөө. Нэвтрүүлгийг бүрэн эхээр байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтэд хүргэсэн. Мөн визийн зөвшөөрөл олгох цахим үйлчилгээний талаарх мэдээллийг Орос, Солонгос хэлээр бэлтгэж олон нийтэд хүргэлээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх зорилгоор байгууллагын даргын гурван удаагийн удирдамжийн дагуу байгууллагын төв болон Сэлэнгэ аймгийн Хойд бүс дэх газар, Дорноговь аймаг дахь газрын албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, холбогдох дүрэм, зааврын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийн, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах үүрэг, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 42 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 32 өргөдөл шийдвэрлэгдэж, 10 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”, “Хил орчмын аялал, жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын тогтоол, “Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч тээврийн хэрэгслийн нэгдсэн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох журам”, “Зөрчлийн талаарх мэдээллийг төлбөртэй авах журам”-ын төсөлд тусгах саналыг тус тус боловсруулан албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлж ажиллав.

Тус байгууллагаас төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах талаар 2001 оноос хойш байгуулсан 16 гэрээ, журам, тушаал болон санамж бичгүүдийг цэгцлэх ажлын хүрээнд дээрх эрх зүйн актуудын хэрэгжилтийг дүгнэх, цаашид хэрхэх тухай санал солилцох талаар албан бичиг боловсруулан Татварын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төвд тус тус хүргүүлсэн.

Тайландын Вант Улсын Бангкок хотноо 05 дугаар сарын 29-өөс 31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “2019 оны харьяалалгүй хүнтэй холбоотой бүс нутгийн дээд хэмжээний бэлтгэл ажлыг хангах төлөөлөгчдийн уулзалт”-д тус

байгууллагын Дэд дарга, Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтнийг хамруулах ажлыг зохион байгуулав.

Мөн Байгууллагын дарга 06 дугаар сарын 03-аас 05-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсын Нур-Султан хотноо зохион байгуулагдсан “Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын Гадаад харилцааны яамд хоорондын консулын IX зөвлөлдөх уулзалт”-д оролцож, албан томилолтоор ажиллалаа.

2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Архивын ерөнхий газрын Мэдээллийн технологийн хэлтсээс нэвтрүүлсэн “AMS” программ хангамжийг байгууллагын архивт ашиглахаар суурилуулан ажиллагаанд оруулсан.

“ISM” системээс “Evisa” системд ашиглагдах 12 төрлийн үйлчилгээг програмчиллаа.

2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6.27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 06 дугаар сард 3.49 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 2.59 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2019 оны 06 дугаар сарын байдлаар 2 тэрбум 555 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 528,1 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 74,9 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Багаж техник, хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан “Блүүмвейв” ХХК-аас 176,9, нормын хувцасны тендерт шалгарсан “Хос аз” ХХК-аас 31,5, “Амно фейшн” ХХК-аас 68,8, “Батзүү” ХХК-аас 7,1, “Цагаан шонхор” ТӨҮҮГ-аас 102,4 сая төгрөгийн бараа, материал, хувцас хэрэглэлийг гэрээнд заасны дагуу хүлээн авсан.

2.5. Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 05 дугаар сарын мэдээг Үндэсний аюулгүй байдлын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын албанд, статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгийн тус байгууллагад холбогдолтой зүйл, заалтуудын 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн даргын дэргэдэх зөвлөлийн 04 дүгээр хурлаар хэлэлцүүлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны “Байгууллагын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийх, дахин хуваарилах, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” А/65 дугаар тушаалын дагуу тус ажлын хэсгийн гурван удаагийн хуралдаанд оролцон техникийн ажлын

хэсэгт байгууллагын чиг үүргээ танилцуулж, үндсэн нэг, дэд таван чиг үүргийг Засгийн газрын “function.gov.mn” программд орууллаа.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын хилээр 136 орны 79865 гадаадын иргэн хил нэвтэрснээс түүвэрчилж 643 гадаадын иргэдийн хил нэвтрэлтэд хяналт тавихад Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй хоёр иргэнийг гарах-орох визгүй нэвтрүүлсэн гурван зөрчил илрүүлэв.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 189 дүгээр тушаалаар байгуулагдсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын авто тээврийн хэлэлцээрийг шинэчлэх талаар хятадын талаас ирүүлсэн саналыг судлан санал боловсруулж, хятадын талтай тохирох үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн уулзалт, Сангийн сайдын 2018 оны 235 дугаар тушаалаар байгуулагдсан “Цагаан дэл-Уул-Өлзий хилийн боомтыг ижил түвшинд төлөвлөх, хөрөнгө оруулалтын хэмжээг тохиролцох, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гаргах, эдгээр ажлын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн хуралд тус байгууллагыг төлөөлж Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга оролцсон.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын хэсгээс Өмнөговь аймагт зохион байгуулсан сургалтад хоёр, Өмнөговь аймгийн Насан туршийн боловсрол төвөөс зохион байгуулсан сургалтад 10, Үндэсний статистикийн хороо, Өмнөговь аймгийн Статистикийн хэлтсээс зохион байгуулсан сургалтад хоёр, Төрийн албаны зөвлөлөөс Ховд аймагт зохион байгуулсан сургалтад хоёр, Үндэсний хөгжлийн газраас Ховд аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтад хоёр, Архивын улсын үзлэгийн бэлтгэл ажилтай холбогдуулан Ховд аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтад хоёр, Удирдлагын академи, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан сургалтад нэг албан хаагч тус тус хамрагдлаа.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР